



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/66

Аргатай

┌ Авто засварын үйлчилгээ эрхлэх ┐
зээл олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "б", 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дугаар тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрээр Хоршоог хөгжүүлэх сангаас Энгэр-Ус 2 дугаар багийн иргэн Ш.Доржтовуу (ЗЮ95052552) "Авто засварын үйлчилгээ" чиглэлээр нийт 20,000,000 (хорин сая) төгрөгийг иргэний харилцах дансанд төвлөрүүлэхийг нягтлан бодогч (Э.Хандсүрэн)-д даалгасугай.

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт тайлагналтад хяналт тавьж ажиллахыг Хоршоог хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлд даалгасугай.

3. Зээлдэгч иргэдийн зээлийн эргэн төлөлт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Э.Сувд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



О.МУУГАНБААТАР